

ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

*ҮАГазраас 2016 онд нийлүүлэх аудитын болон үйл ажиллгааны төлөвлөгөөний дагуу
хийсэн нийцлийн аудитын тайлан*



ТӨВ АЙМГИЙН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН НАМ ЭВСЛИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

2016 ОН

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	
Төв аймгийн аудитын газар	Товчилсон үгсийн тайлбар 3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	Асуудал 1
Аудитын менежер О.Амаржаргал	Сумын ИТХ-ын сонгуульд МАН-аас 527 нэр дэвшигч оролцож 35.59 сая төгрөг, “АН-МАХН”-ын “Төв нутаг эвсэл”-ээс 510 нэр дэвшигч оролцож 27.66 сая төгрөг зарцуулсан байна. 5
Ахлах аудитор Т.Майцэцэг Ц.Базарсад Ц.Саранчимэг	Асуудал 2
Аудитор: Д.Пүрэвсүрэн О.Сосор Ж.Бямбацогт	МАН 19.15 сая төгрөгийн, “Төв нутаг эвсэл” 10.72 сая төгрөгийн хандивын орлогыг тайлагнасан байна. 7
Шинжээч Ч.Бат-Эрдэнэ Ч.Загдсүрэн Ц.Хишигжаргал А.Батлхагва	Дүгнэлт 9 Зөвлөмж 10
2016 оны 12 дүгээр сарын 23-ны өдөр	
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар 70272582, 70273204 дугаарын утас, 70272248 дугаарын факсаар харилцана уу	
ХАЯГ: Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
СТХ	Сонгуулийн тухай хууль
СТБ	Сонгуулийн төв байгууллага
САСТХ	Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
ТАХ	Төрийн аудитын тухай хууль
ТТХ	Төсвийн тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НББ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгийн хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2016 онд нийлүүлэх аудитын болон үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт , хамарсан хүрээ

Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу зарцуулсан эсэх
- Хөрөнгийн зарцуулалтад тавьж буй хяналт үр дүнтэй эсэх

Аудитад аймгийн болон сумдын сонгуулийн хороодын санхүүгийн баримт материал, батлагдсан төсвийн төлөвлөгөө гүйцэтгэл, цагийн бүртгэл, урамшуулал, хоол унааны мөнгө олголт, бараа материалын тайлангууд, сонгуулийн хороо болон хэсгийн хороодын даргын захирамжууд зэрэг материалууд хамрагдсан болно.

Сумдын Сонгуулийн хороод санхүүгийн баримт болон зарцуулалтын тайлангуудыг 2016 оны 10 сарын 28-нд, аймгийн Сонгуулийн хороо сонгуулийн зардалын зарцуулалтын тайлан болон санхүүгийн баримтуудыг 2016 оны 11 сарын 08-нд Аудитын байгууллагад ирүүлсэн.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитыг АДБОУС-4000, Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

Төрийн аудитын тухай хууль

Төсвийн тухай хууль

Сонгуулийн тухай хууль

Сонгуулийн төв байгууллагын тухай

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль

СЕХ-ны 2016 оны 4-р тогтоол

Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан холбогдох бусад хууль, тогтоомжууд

Аудитыг Төв аймгийн Аудитын газрын менежер О.Амаржаргал удирдан, аудитор ахлах аудитор Т.Майцэцэг, Ц.Базарсад, Ц.Саранчимэг, аудитор Д.Пүрэвсүрэн, О.Сосор, Ж.Бямбацогт, шинжээч Ц.Хишигжаргал, Ч.Загдсүрэн, А.Батлхагва, Ч.Бат-Эрдэнэ нар 2016 оны 12-р сарын 01-нээс 12-р сарын 23-нийг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэв.

Асуудал 1

Сумын ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвслийн тайлан

1.1 Сонгуульд оролцосон нам, эвслийн талаар

Сумын ИТХ-ын сонгуульд МАН-аас 527 нэр дэвшигч оролцож 35.59 сая төгрөг, “АН-МАХН”-ын “Төв нутаг эвсэл”-ээс 510 нэр дэвшигч оролцож 27.66 сая төгрөг зарцуулсан байна.

Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдөр “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 06 дугаар тогтоол, 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдөр “Сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 27 дугаар тогтоол, “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” 28 дугаар тогтоолыг тус тус баталсан. Төв аймгийн сумын ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулиар 27 сумын 96 багаас 529 мандатын төлөө өрсөлдөхөөр 1108 нэр дэвшигч бүртгүүлснээс “МАН”-аас 527, “Ардчилсан нам-МАХН”-ын “Төв нутаг” эвслээс 510, 71 бие даан нэр дэвшигч бүртгүүлсэн байна.

Нэр дэвшигчдийг сумдаар харуулбал

№	Сумын нэр	Мандатын тоо	Нэр дэвшигчийн тоо			
			МАН	АН МАХН ТНЭ	Бие даагч	Нийт нэр дэвшигч
1	Зуунмод	31	31	31	0	62
2	Алтанбулаг	21	21	21	0	42
3	Аргалант	15	15	15	14	44
4	Архуст	15	15	15	0	30
5	Батсүмбэр	27	27	25	4	56
6	Баян	21	21	18	0	39
7	Баяндэлгэр	15	15	15	0	30
8	Баянжаргалан	15	15	14	0	29
9	Баян-Өнжүүл	21	21	21	0	42
10	Баянхангай	15	15	15	0	30
11	Баянцагаан	15	15	15	0	30
12	Баянцогт	15	15	15	3	33
13	Баянчандмань	21	21	20	3	44
14	Борнуур	27	26	27	6	59
15	Бүрэн	21	21	20	1	42
16	Дэлгэрхаан	15	15	14	0	29
17	Жаргалант	27	26	25	5	56
18	Заамар	27	27	27	0	54
19	Лүн	21	21	21	0	42

20	Мөнгөнморьт	15	15	15	0	30
21	Өндөрширээт	15	15	15	0	30
22	Сүмбэр	15	15	15	0	30
23	Сэргэлэн	15	15	15	7	37
24	Угтаалцайдам	21	21	19	0	40
25	Цээл	21	21	21	20	62
26	Эрдэнэ	21	21	16	0	37
27	Эрдэнэсант	21	21	20	8	49
Нийт		529	527	510	71	1108

Аймгийн МАН-аас сумын ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуультай холбоотой зардал гаргаагүй бөгөөд энэ тухай 2016 оны 12 сарын 01-ний өдрийн 74 дугаарын албан бичгээр мэдэгдсэн.

Аймгийн Ардчилсан намын ХААН банкны 5721011881 дугаарын данс руу ҮЗХ-ны гишүүн Б.Баярсайхан 2.0 сая төгрөг, Гантулга 1.5 сая төгрөг, Х.Өлзий-Орших 3.0 сая төгрөг, гишүүдийн татвар 6.6 сая төгрөг орсныг сумын намын хороо руугаа 11.7 сая төгрөг шилжүүлсэн байна.

Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2016 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн А/15 дугаар тушаалаар сумын ИТХ-ын сонгуульд оролцох нам, эвсэл тус зарцуулах сонгуулийн зардлын дээд хэмжээг 81.5 сая төгрөг тогтоосон байна.

Нам, эвслийн зарцуулсан зардлын хэмжээг хүснэгтээр харуулбал

/мянган төгрөгөөр/

№	Сумын нэр	МАН			эвсэл		
		Орлого	Зардал	Үлдэгдэл	Орлого	Зардал	Үлдэгдэл
1	Зуунмод	7,800.00	6,836.70	963.30	-	-	-
2	Алтанбулаг			-			-
3	Аргалант	4,000.00	2,973.00	1,027.00	985.00	985.00	-
4	Архуст	1,200.00	1,200.00	-			-
5	Батсүмбэр	5,056.00	4,906.20	149.80	3,318.65	3,241.80	76.85
6	Баян	-	-	-	-	-	-
7	Баяндэлгэр	500.00	499.40	0.60	2,040.00	2,040.00	-
8	Баянжаргалан			-			-
9	Баян-Өнжүүл	1,000.00	762.40	237.60			-
10	Баянхангай	1,305.00	1,300.00	5.00	500.00	500.00	-
11	Баянцагаан	1,100.00	502.20	597.80	1,057.20	1,002.20	55.00
12	Баянцогт	300.00	300.00	-	3,209.00	3,209.00	-
13	Баянчандмань	2,810.00	2,810.00	-			-
14	Борнуур	-	-	-	-	-	-
15	Бүрэн	1,580.00	1,580.00	-	1,167.00	1,165.60	1.40
16	Дэлгэрхаан	1,100.00	1,100.00	-			-
17	Жаргалант	1,990.00	1,990.00	-	7,060.30	7,024.40	35.90
18	Заамар			-			-
19	Лүн	3,020.00	3,020.00	-	2,005.00	2,005.00	-
20	Мөнгөнморьт	1,800.00	1,789.90	10.10			-

21	Өндөрширээт	-	-	-	-	-	-
22	Сүмбэр	100.00	100.00	-	700.00	700.00	-
23	Сэргэлэн			-			-
24	Угтаалцайдам	1,667.00	1,600.60	66.40	2,300.00	2,300.00	-
25	Цээл			-			-
26	Эрдэнэ	2,322.00	2,322.00	-	-	-	-
27	Эрдэнэсант			-	3,500.00	3,490.00	10.00
Нийт		38,650.00	35,592.40	3,057.60	27,842.15	27,663.00	179.15

Сумын ИТХ-ын сонгуульд нэг нам /МАН/, нэг эвсэл /“АН-МАХН”-ын “төв нутаг эвсэл”/ оролцож МАН 38.65 сая төгрөг, Төв нутаг эвсэл 27.8 сая төгрөг зарцуулсан зардлын тайланг сумдын сонгуулийн хороонд өгсөн байна. Сонгуулийн зардлын тайлангаас үзэхэд Нам, эвслийн зарцуулсан зардал нь Аудитын газраас тогтоосон сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д “сонгуулийн зардлын тайлан, холбогдох бусад баримт бичгийг хүлээн авсан сонгуулийн байгууллага дараах төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ”, 60.1.2-д “аймаг, нийслэл, сум дүүргийн сонгуулийн байгууллага аймаг, нийслэлийн төрийн аудитын байгууллагад” гэж заасны дагуу сумын сонгуулийн хороод ИТХурлын сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Орон нутгийн хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл

Асуудал 2

Нам, эвсэлийн сонгуулийн хандив, зарцуулалт

МАН 19.15 сая төгрөгийн, “Төв нутаг эвсэл” 10.72 сая төгрөгийн хандивын орлогыг тайлагнасан байна.

Сумын ИТХ-ын сонгуульд оролцсон МАН-ын дансанд 45 иргэний 19.15 сая төгрөгийн хандив, Ардчилсан намын дансанд 30 иргэний 9.72 сая төгрөг, 1 хуулийн этгээдийн 1.0 сая төгрөгийн хандив цугларсан нь Сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд “сонгуулийн хандив нь мөнгөн болон мөнгөн бус хэлбэртэй байна, хандивлагч нь хуульд заасан шаардлагыг хангасан, Монгол Улсын иргэн байна” гэсэн заалттай нийцэж байна.

Төв аймгийн орон нутгийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл нь Сонгуулийн тухай хуулийн 50, 51, 52 дугаар зүйлд заасан шаардлагын хүрээнд хандивын орлогыг бүрдүүлэн зарцуулсан байна.

Баяндэлгэр сумын АН нь 1.4 сая төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлэлгүй зарцуулсан байна. Энэ нь “Сонгуулийн тухай” хуулийн 40.3-т “Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийг банкинд нээлгэсэн сонгуулийн зардлын дансанд энэ хуульд заасан журмын дагуу төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулна”, 40.5-д “сонгуулийн зардлын данснаас өөр дансанд болон хандивын бус аргаар сонгуулийн зардал цуглуулах, түүнчлэн бэлэн мөнгөөр хүлээн авсан хандивыг зардлын дансанд оруулахгүйгээр зарцуулахыг хориглоно”, 45.9-д “Эвсэлд нэгдсэн

намууд нь тус тусын намын сонгуулийн зардлын дансанд цугласан мөнгөн хөрөнгийг эвслийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлэн, уг данснаас эвслийн сонгуулийн зардлыг гаргана”, “45.10-т “эвсэлд нэгдсэн намын сонгуулийн данснаас эвслийн сонгуулийн зардлын дансанд мөнгө шилжүүлэхээс бусад тохиолдолд тухайн ээлжит сонгуулийн хугацаанд буюу эвсэл тарах хүртэл хугацаанд эвсэлд нэгдсэн нам бие даан сонгуулийн зардал гаргахыг хориглоно” гэсэн заалтууд зөрчигдсөн байна.

МАН-д иргэдээс өгсөн нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив

/мянган төгрөгөөр/					
№	Сумын нэр	Намын нэр	хандивлагч иргэн овог нэр	регистр	хандивын хэмжээ
1	Аргалант	МАН	С.Сэргэлэн	НБ55092696	1,000.0
2	Баянцагаан	МАН	Тунглаг		1,100.0
3	Баянчандмань сум	МАН	Нэргүй	нх78122215	1,000.0
4	Баянчандмань сум	МАН	Балжинням	ЧМ42030531	1,000.0
5	Бүрэн	МАН	Батмөнх	НФ68070415	1,580.0
6	Жаргалант	МАН	Цэндээ		1,000.0
7	Жаргалант	МАН	Өлзийорших		1,000.0
8	Лүн	МАН	Мөнхбат	НО68122870	2,000.0
9	Угтаал	МАН	Энхболд	НН70062773	1,600.0
	Нийт дүн				11,280.0

АН-д иргэдээс өгсөн нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив

/мянган төгрөгөөр/					
№	Сумын нэр	Намын нэр	хандивлагч иргэн овог нэр	регистр	хандивын хэмжээ
1	Батсүмбэр	АН	Г. Баярсайхан	ШБ72022515	1,000.0
2	Төв	АН	Б.Баярсайхан	ЧЛ67082074	2,000.0
3	Төв	АН	П.Гантулга	ЧТ81100334	1,500.0
4	Төв	АН	Х.Өлзий-Орших	УХ75081815	3,000.0
	Нийт дүн				7,500.0

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Сумын ИТХ-ын сонгуульд МАН-аас 527 нэр дэвшигч оролцож 35.59 сая төгрөг, “АН-МАХН”-ын “Төв нутаг эвсэл”-ээс 510 нэр дэвшигч оролцож 27.66 сая төгрөг зарцуулсан байна.
2. МАН 19.15 сая төгрөгийн, “Төв нутаг эвсэл” 10.72 сая төгрөгийн хандивын орлогыг тайлагнасан байна.
3. Баяндэлгэр сумын АН 1.4 сая төгрөгийн орлогыг сонгуулийн харилцах дансанд төвлөрүүлэлгүй зарцуулсан байна.

ЗӨВЛӨМЖ

Баяндэлгэр сумын АН-ын хорооны даргад зөвлөх нь

1. Сонгуулийн үйл ажиллагаанд зориулж хандивласан мөнгөн хөрөнгийг сонгуулийн дансанд байршуулж зарцуулж байх

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР:

О.АМАРЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ
Ц.БАЗАРСАД
Ц.САРАНЧИМЭГ

АУДИТОР

Д.ПҮРЭВСҮРЭН
О.СОСОР
Ж.БЯМБАЦОГТ

ШИНЖЭЭЧ:

Ч.БАТ-ЭРДЭНЭ
Ц.ХИШИГЖАРГАЛ
Ч.ЗАГДСҮРЭН
А.БАТЛХАГВА